



**АУДИТ, ХӨРӨНГИЙН  
ҮНЭЛГЭЭНИЙ САНХҮҮГИЙН  
ЗАХ ЗЭЭЛД ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ,  
ЗОХИЦУУЛАЛТЫН  
ТОГТОЛЦОО**

**Ц.ЖИГДЭН**

**Монголын Мэргэшсэн Нягтлан**

**Бодогчдын Институтийн Ерөнхийлөгч**



АУДИТ, ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ  
САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО

Санхүүгийн зах зээл нэг талаас хөрөнгө босгох, бизнесээ өргөжүүлэх ашиг сонирхол бүхий компани, хувь хүмүүсийн, нөгөө талаас өөрт байгаа мөнгөн хуримтлалыг зах зээлд гаргаж хөрөнгөө өсгөх, эргэлтэд оруулах баталгаатай, ашигтай бизнест хөрөнгө оруулах хүсэл эрмэлзэлтэй компани, хувь хүмүүсийн хүрээнд явагддаг үйл ажиллагаа юм.

# САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧ ТАЛУУД



Хувьцаа гаргаж байгаа этгээдийн нийтэд толилуулж байгаа байгууллагын бодлого, стратеги, засаглал, дотоод хяналт, санхүү, эдийн засгийн мэдээлэл, цаашдын чиг хандлага зэргийн үнэн бодит байдлыг хангаж хэрэглэгчдэд шударга мэдээллийг хүргэх зорилго бүхий үйл ажиллагааг явуулдаг

# САЛБАРЫН ХӨГЖИЛ

1993.02.08



**Нягтлан  
бодох  
бүртгэлийн  
тухай хууль**

1996.03.09



**Монголын  
Мэргэшсэн  
Нягтлан  
Бодогчдын  
Институт**

1997.05.01



**Аудитын  
тухай хууль**

2005



**Монголын  
Мэргэшсэн  
Үнэлгээчдийн  
Институт**

2010



**Хөрөнгийн  
үнэлгээний  
тухай  
хууль**

2015.06.19

**Нягтлан бодох  
бүртгэлийн  
болон Аудитын  
тухай хуулиуд**

- ✓ 2000 онд 23 орныг эгнээндээ нэгтгэсэн Ази Номхон Далайн Нягтлан Бодогчдын Холбоонд жинхэнэ гишүүнээр
- ✓ 2012 онд 131 орныг эгнээндээ нэгтгэсэн Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны жинхэнэ гишүүнээр

- ✓ 2015 онд 56 орныг эгнээндээ нэгтгэсэн Үнэлгээний Олон Улсын Стандартын Консулын гишүүнээр



## БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖИЛТЭН

**АУДИТЫН КОМПАНИ – 130**

**ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА – 20**

**АУДИТОР – 700**

**МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧ – 3800**

**ҮНЭЛГЭЭЧИН – 300**

**ОЛОН УЛСЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН  
БОДОГЧ – 30 /АССА/**



## СТАНДАРТ, АРГА ЗҮЙ

- 1993 оны “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, 1997 оны “Аудитын тухай” хууль, 2010 оны “Хөрөнгийн үнэлгээний тухай” хуулиудад Нягтлан бодох бүртгэл, Аудит, Хөрөнгийн үнэлгээний олон улсын стандартыг дагаж мөрдөхөөр хуульчилсан.
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг 4 удаа,
- Аудитын олон улсын стандартыг 4 удаа,
- Хөрөнгийн үнэлгээний олон улсын стандартыг 3 удаа бүрэн эхээр нь орчуулсан.
- “Нягтлан бодох бүртгэл тухай” 2015 оны шинэчилсэн хуулиар Сангийн сайдын дэргэд Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хороог байгуулахаар тусгасан

Олон улсын стандартыг дагаж мөрдөж байгаа нь ололт, амжилт боловч нөгөө талаас стандартуудыг эх хэлнээ орчуулж хэрэглэх, аж ахуйн нэгжийн хөгжил, үйл ажиллагааны цар хүрээ, засаглалын төлөвшилтэй уялдуулж өөрийн орны онцлогт тохирсон үндэсний стандарттай болох нь чухал байна.



## НЭГДМЭЛ ТАЙЛАГНАЛ

- Манай улсын хувьд бүртгэл, тайлагналын тогтолцоо нь 100 гаруй жилийн түүхийг бүтээсэний дотор сүүлийн 20 гаруй жилд дэлхийн улс, орнуудын нийтлэг хэрэглэгддэг арга зүй, чиг хандлагыг хэрэглэж байна.
- Энэ нь байгууллагын тайлагналын зөвхөн санхүүгийн үзүүлэлтийг илэрхийлэх талаасаа хэлбэржин иржээ.
- Гэвч хөрөнгө оруулагч, мэдээлэл хэрэглэгч, оролцогч талуудын эрх ашиг, хэрэгцээ шаардлагын улмаас тухайн байгууллагын талаарх иж бүрэн мэдээллийг илэрхийлж чадахгүй байна.

Богино, дунд, урт хугацаанд байгууллагын үнэт зүйлийг бий болгох бодлого, стратеги, засаглал, санхүүгийн үзүүлэлт, хэтийн төлөвийг харуулсан товч тодорхой мэдээ мэдээлэл бүхий нэгдмэл тайланг тайлагнахыг шаардаж байна.





## БАТАЛГААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ЧИГЛЭЛ

- Өнгөрсөн 20 гаруй жилд санхүүгийн тайлангийн аудитыг түүхэн мэдээлэлд үндэслэн гүйцэтгэж ирсэн нь мэдээлэл хэрэглэгч, оролцогч талуудын зах зээлийн хэрэгцээ шаардлагыг бүрэн дүүрэн хангаж чадахгүй байна.
- Түүнчлэн аудиторын дүгнэлт, зөвлөмжийг шийдвэр гаргагч болох төрийн болон тухайн байгууллагын удирдлага, хувьцаа эзэмшигчид хэрэглээ болгон ашиглаж чадахгүй байна.
- Санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэх байгууллагуудыг хуульчилж өгсөн нь аудитын хөгжилд тодорхой түлхэц болж байсан боловч бизнес эрхлэгч, хувьцаа эзэмшигчдийн эрэлтэд суурилагагүй байсан аудитын үйлчилгээний чанар, ажлын хөлсийг унагах, шударга бус өрсөлдөөнийг бий болгож байна.

Баталгаажуулалтын бусад төрөл, чиглэлүүдийг тусгайлан зааж өгсөн нь мэдээлэл хэрэглэгч, оролцогч талуудын хэрэгцээг хангахад чухал үүрэгтэй болсон юм.

Мөн шинэчилсэн хуулиар нийтийн ашиг сонирхол бүхий байгууллагаас бусад байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээг үзүүлэхээр тусгасан.

Дээрх үйлчилгээний үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэхэд хэрэглэгч, оролцогч талуудын үүрэг, хариуцлага юу юунаас чухал байна.





## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хөрөнгийн үнэлгээ нь аливаа хөрөнгө, өмчлөх эрх, санхүүгийн хэрэглүүр зэрэг биет болон биет бус хөрөнгө болоод бизнесийн үйл ажиллагааны бодит үнэ цэнийг тогтооход чиглэсэн санхүүгийн үйлчилгээний нэгэн төрөл юм.

- “Аливаа оршин байгаа бүхэн хэмжигддэг” гэж үздэг. Манай улсад газар, түүний нөөц баялаг, байгаль орчин, оюуны өмч гээд оршин байгаа асар их өмч хөрөнгө үнэ цэнэ нь тогтоогдоогүй бүртгэл тайланд тусгаагүй олон арван жил явж ирсэн.
- Компанийн өмчийн эзэд, зээл олгогч, удирдлага, бүх шатны менежер зэрэг олон мэдээлэл хэрэглэгчид санхүүгийн тайланд өмч, хөрөнгийг бодит үнэ цэнээр тодорхойлж байх ёстой гэж шаардах боллоо.
- Ингэснээр хөрөнгийг анхны өртөгөөр тооцож байсан уламжлалаас бодит үнэ цэнээр тооцдог аргачлалд шилжиж олон улсын үнэлгээний стандартын шаардлага хангагдана. Үүнийг зах зээлийн эдийн засагт шилжсэн орнууд санхүүгийн тайлангийн зорилгоор хөрөнгийг үнэлэх гэж нэрлэж байна.

Энэ өөрчлөлт шинэчлэлийн гол ачааг чухамдаа үнэлгээчин, эдийн засагч, санхүүч, нягтлан бодогч бид үүрч байгаа билээ. Тиймээс энэхүү өөрчлөлт шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд бид өөрсдийгөө эхлээд өөрчилж хөгжүүлэн, шинэ орчин нөхцөлд ажиллах мэдлэг, ур чадвартай болж, хууль эрх зүй, мэргэжлийн ёс зүй, стандарт, үнэлгээний горимыг мөрдөж ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.



## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

- Үнэлгээний хөгжил нь үл хөдлөх хөрөнгийн зах зээл, түүний үйл ажллагаанд суурилдаг. Үл хөдлөх хөрөнгө нь эдийн засгийн дэд бүтцийн нэг бөгөөд түүний 5 дахь эх үүсвэр ч гэж үздэг.
- Үнэлгээ өргөн утгаараа улс орны болон үнэлж байгаа бүхий л зүйлийн өртөг, зардал, ашиг орлогыг тооцоолон улс орны эдийн засгийн өсөлтийг тодорхойлдог. Ингэснээр цаашдын төлөвийг гаргаж хөрөнгө оруулалтын төслийг хийх үндсийг бүрдүүлэх талтай.
- Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ нь үнэлгээчнээс өндөр мэдлэг, туршлага, ур чадвар, ёс зүйн хэм хэмжээг шаарддаг. Манай үнэлгээний компаниудын ажиллах хүчний чадавхи жилээс жилд дээшилж байгаа хэдий ч дэлхийн глобалчлал, улс орны өнөөгийн хөгжлийн хурдац, нийгмийн хөгжлийн шаардлагыг тэр бүр гүйцэж чадахгүй байна.

Иймд төрийн болон мэргэжлийн байгууллагууд, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөллийг оролцуулсан үнэлгээний стандартын хороог тусгайлан байгуулж ажиллуулах шаардлагатай байна. Хөрөнгийн үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлж үнэлгээчдийг нэгдсэн мэдээллээр хангах, хөрөнгийн үнэлгээний үндэсний стандартыг боловсруулан гаргах шаардлагатай байна.

# МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улсад санхүүгийн зах зээл, нягтлан бодох бүртгэл, аудит, хөрөнгийн үнэлгээ үүсч хөгжсөн 20 гаруй жилийн хугацаанд үе үеийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүд сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан мэргэжлийн байгууллагууд болох

- **Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт,**
  - **Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институт,**
  - **Татварын Мэргэшсэн Зөвлөх Үйлчилгээний Нийгэмлэг**
- гэхчилэн төрийн бус байгууллагуудыг байгуулж өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлж, мэргэжлийн байгууллагын чадамжийг нэмэгдүүлэх, төрийн бодлогыг тодорхойлоход дуу хоолой, санал бодлоо нэгтгэн, төр засагтаа дэмжлэг үзүүлж ирсэнээс гадна олон улсын түвшинд хүрэхүйц холбоо, институци болоод байгаагаа тэмдэглэн хэлэх байна.



- ✓ Хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт боловсруулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх;
- ✓ Хөрөнгийн үнэлгээ хөрөнгийн арилжааны зах зээлийн баталгаажсан мэдээллийг төрийн аль нэг байгууллагад албан ёсоор бүртгэдэг болохыг төрөөс зохицуулах шаардлагатай.
- ✓ Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага, энэ асуудлыг хариуцсан төрийн байгууллагын үүрэг, оролцоог нарийн зааглаж, мэргэжлийн байгууллага, холбоодыг ямар шалгууртай хүч байхыг хуульчлах шаардлагатай.



**АНХААРАЛ ТАВЬСАНД  
БАЯРЛАЛАА**